

**"АПУ" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2025 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 25/01

Улаанбаатар хот

АПУ ХК (цаашид "Компани" гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал цахим хэлбэрээр 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 14 цаг 00 минутад эхлэв. Хурлыг БиДиСек ҮЦК ХК-ийн хөгжүүлсэн хувьцаа эзэмшигчдийн хурлын www.agm.mn програм хангамжийн тусламжтай, Лайвстрийм ХХК-ийн шууд дамжуулалтаар явуулав.

Хуралд оролцсон:

1. Гүйцэтгэх захирал бөгөөд хурлын дарга Ц.Эрдэнэбилэг
2. ТУЗ-ийн хараат бус гишүүн, Цалин урамшууллын хорооны дарга Ё.Гэрэлчулуун
3. ТУЗ-ийн хараат бус гишүүн, Нэр дэвшүүлэх хорооны дарга О.Одбаяр
4. ТУЗ-ийн хараат бус гишүүн, Аудитын хорооны дарга Ж.Үнэнбат (цахимаар)
5. Санхүү эрхэлсэн захирал Г.Энхбилэг
6. Хөндлөнгийн аудитор Кэй Пи Эм Жи Аудит ХХК-ийн партнер Жу Сан Ён (цахимаар)
7. Хөндлөнгийн аудитор Кэй Пи Эм Жи Аудит ХХК-ийн захирал Татьяна Яковлева (цахимаар)
8. Хөндлөнгийн аудитор Кэй Пи Эм Жи Аудит ХХК-ийн төлөөлөл Б.Гэрэл (цахимаар)
9. Тооллогын комиссын дарга Бидисек ҮЦК ХК-ийн хөрөнгө оруулалтын албаны захирал С.Дөлгөөн

Хурлын нарийн бичгийн дарга:

1. Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ" гэх)-ийн нарийн бичгийн дарга Б.Сарантунгалаг

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Сарантунгалаг хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулж, хурлын дэгийн дагуу бүртгэлийн ажиллагааны дүнг гаргаж, ирцийн мэдээг танилцуулна уу хэмээн тооллогын комиссын дарга С.Дөлгөөнийг урив.

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах,
2. Компанийн ТУЗ-ийн цалин, урамшууллыг хэлэлцэж батлах.

Хурлын ирц:

Тооллогын комиссын дарга С.Дөлгөөний танилцуулснаар:

Хуралд **935,499,516 ширхэг** энгийн хувьцаа эзэмшиж буй **222** хувьцаа эзэмшигч оролцож байгаа нь нийт саналын эрхтэй **1,064,181,553 ширхэг** энгийн хувьцааны **87.91%** болж байгаа тул Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1, 69 дүгээр зүйлийн 69.1, 69.2 дахь хэсэг, Компанийн Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.11 дэх хэсгийг үндэслэн хурлыг хүчин төгөлдөрт тооцов.

Ийнхүү ирц бүрдсэн тул хурлын дарга Ц.Эрдэнэбилэг хурлыг нээж, 2024 он бол АПУ-чууд төдийгүй Монгол Улсын аж үйлдвэрийн салбар, тэр дундаа шингэн хүнсний салбарын хөгжлийн 100 жилийн ой тохиосон, өнгөрсөн зууны ололт амжилтаа дүгнэн, дараачийн зууны хөгжлийн бодлого, стратегия тодорхойлсон жил болж өнгөрснийг онцлов.

Хэлэлцсэн нь:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах

Танилцуулсан нь:

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулахдаа дараах зүйлсийг онцлов. Үүнд:

- Компанийн 100 жилийн ойн босгон дээр эрхэм зорилго, алсын хараа үнэт зүйлсээ шинэчлэн тодорхойлж, “Үргэлж өөдөө” уриа үгтэйгээр ажиллав.
- Цэвэр борлуулалтын орлогыг 20%-аар өсгөж, 1.3 их наяд төгрөгт хүргэсэн түүхэн амжилт үзүүллээ.
- Борлуулалтын биет хэмжээг 171 сая литр буюу өмнөх оны түвшинд хадгалав.
- Цэвэр ашгийг 65%-аар өсгөж, 193 тэрбум төгрөгт хүргэв.
- Улсын төсөвт нэг өдөрт 1.3 тэрбум буюу нийт 474 тэрбум төгрөгийн татвар төлсөн.
- 2,400 гаруй ажилтантайгаар бүтээгдэхүүний нэр төрлөө нэмэгдүүлэн ажиллав.
- Ойн баярын хүрээнд жилийн туршид нийгэм, харилцагч, хамт олонд хандан ирээдүйн үнэ цэнд чиглэсэн томоохон арга хэмжээнүүдийг зохион байгуулав.
- Дэлхийд тэргүүлэгч Хайнекен шар айргийг эх орондоо үйлдвэрлэж эхэлсэн нь АПУ компанийн үйлдвэр дэлхийн шилдгүүдийн чанар стандартыг хангасныг нотлон харууллаа.
- АПУ Дэйри сүүний бизнесийг эрчимжүүлэхээр ЕСБХБ, АХБ-тай 40 сая ам.долларын санхүүжилтийн гэрээ үзэглэж, томоохон бүтээн байгуулалтуудыг хийж байна.
- Үйлдвэрийн хаягдал усыг цэвэршүүлэх хаягдал ус боловсруулах үйлдвэрийн төслийг хэрэгжүүлж, ирэх онд ашиглалтад оруулахаар зорин ажиллаж байна.
- Экспортыг хөгжүүлэхэд анхааран, ялангуяа Чингис Хаан брэндээр дамжуулан Монгол Улсыг дэлхий нийтэд таниулахаар хүчин чармайлтаа дайчилж байна.
- Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн үйл ажиллагааг харилцагч, хэрэглэгчийн судалгаа, ирээдүйн чиг хандлагад нийцүүлэн явуулж, спиртийн агууламж багатай, эрүүл бүтээгдэхүүн хөгжүүлэхэд анхаарч байна.
- Хүн төвтэй засаглалыг хөгжүүлж, ажилтанд чиглэсэн хөнгөлөлт, урамшуулал, сургалт, хөгжлийн цогц хөтөлбөрийг хэрэгжүүлснээр ажилтны тогтвор суурьшил, сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд анхаарав.
- АПУ групп компанийн бүтцэд 100%-ийн эзэмшлийн 9 охин компани, 39%-ийн эзэмшлийн 1 хараат компани (Дижитал концепт ХХК) ордог.
- Компанийн 56.6%-ийг Шунхлай холдинг ХХК, 25%-ийг Хайнекен Азия Пасифик Пте Лтд, 5.6%-ийг Степпе Бэвэриж КФТ, 12.8%-ийг бусад 32 мянга гаруй хувьцаа эзэмшигчид эзэмшдэг.
- Ногдол ашгийг жилд хоёр удаа тогтмол хуваарилж байгаа ба 2024 оны нийлбэр дүнгээр нэгж хувьцаанд 120 төгрөг, нийт 127.7 тэрбум төгрөгийг ногдол ашигт хуваарилсан нь өнмөх оноос 35% өссөн үзүүлэлт юм.
- Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн хянан баталгаажсан үнэлгээгээр 94.4%-тай үнэлүүлж, МХБ-д бүртгэлтэй нээлттэй хувьцаат компаниуд дунд дөрөвдүгээрт эрэмбэлэгдлээ.
- Тогтвортой хөгжлийн 2030 он хүртэлх “Бахархалт Монгол” стратегийг боловсруулж, ТУЗ-өөр батлуулав.

ТУЗ-ийн хараат бус гишүүн О.Одбаяр 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн "АПУ групп компани 2024 онд тавьсан зорилтуудаа биелүүлж, амжилттай ажилласан" гэсэн дүгнэлтийг танилцуулж, амжилттай сайн ажилласан нийт ажилтнууд, гүйцэтгэх удирдлагын багт талархсанаа илэрхийлэв.

Асуулт хариулт:

Хувьцаа эзэмшигч Ш.Түмэнбаяр:

- Евразийн эдийн засгийн хэлцлийн талаарх компанийн бодлого, үзэл баримтлал юу вэ?

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг хариулсан нь:

- Өнгөрөгч оноос өрнөсөн Евразийн эдийн засгийн холбоотой хийх чөлөөт худалдааны хэлэлцээр нь дотоодын үйлдвэрлэгчдэд үр дүнгүй, цагаа олоогүй, үйлдвэрлэгчдийн боломжийг хааж болзошгүй, Монгол Улсад ашиггүй хэлцэл хэмээн үзэж, биднээс гадна төрийн болон төрийн бус байгууллагууд, дотоодын үйлдвэрлэл эрхлэгчид эсэргүүцсэн байр сууриа илэрхийлсэн. Гадаад улс, Монгол Улсад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөг 25%-30%-ийн зөрүүтэй байгаа энэ үед гаалийн татварыг тэглэх нь үйлдвэрлэгч компаниудад ихээхэн халтай, сорилттой нөхцөл байдал үүсгэнэ. Уг хэлэлцээр Монгол Улсад ашигтай эсэх талаар хөндлөнгийн, мэргэжлийн судалгааны байгууллага болох МУИС-ийн судалгааны төвөөс хийсэн судалгааны үр дүнгээр энэхүү хэлцэл нь нийтлэгээрээ Монгол Улсын эдийн засаг, дотоодын үйлдвэрлэгчид, хэрэглэгчдэд алдагдалтай, сөрөг нөлөөтэй гэсэн дүгнэлт гарсан. Маш цөөн бүтээгдэхүүн, салбарт зэрэг нөлөө үзүүлэхийг үгүйсгэхгүй. Гэвч шийдвэр гаргагчид Монгол Улсад үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд асар их сорилт тулгардгийг ойлгож байгаа хэмээн найдаж, УИХ, төр засгийн шийдвэрийг хүлээх л үлдэж байна.

Хувьцаа эзэмшигч Б.Ганболд:

- Экспортын борлуулалт нийт борлуулалтын орлогын хэдэн хувийг эзэлж байгаа вэ?

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг хариулсан нь:

- Монголд үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний түүхий эд, туслах материал импортоос ихээхэн хамааралтай байгаа нь өртөг өндөр байхад нөлөөлж, экспортын зах зээлд өрсөлдөх чадвар бага байна. Бидэнд зөвхөн премиум болон супер премиум зах зээлд өрсөлдөх боломж байгааг алдахгүй ашиглахыг зорьж байна. ОХУ-ын зах зээлд борлуулалтыг өмнөх оноос 50%-аар өсгөж, БНХАУ-ын зах зээлд мөн өсөлттэй ажилласан ч нийт борлуулалтад экспортын борлуулалт дорвитой хувь эзэлж чадахгүй байна. Экспортын эзлэх хувийг ирээдүйд 20%-д хүргэх зорилттой ажилласаар байна.

Хэлэлцсэн нь:

2. Компанийн ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллыг хэлэлцэж батлах

Танилцуулсан нь:

ТУЗ-ийн хараат бус гишүүн, цалин урамшууллын хорооны дарга Ё.Гэрэлчулуун ТУЗ-ийн бүрэлдэхүүн болон ТУЗ-ийн цалин урамшууллын саналыг танилцуулахдаа дараах зүйлсийг онцлов:

- Өнгөрөгч 2024 онд ТУЗ-ийн гишүүн Сергей Громов, Доржийн Миеэгомбо нар чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан тул оронд нь Батсайханы Гантиг, Баярцогтын Гомбо-Эрдэнэ нарыг нэр дэвшүүлснээр 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар одоогийн бүрэлдэхүүнийг 3 жилийн хугацаатай сонгосон.
- ТУЗ-ийн 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн хурлаар ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Чадраабалын Ариунсанг чөлөөлж, Базаррагчаагийн Сарантунгалагийг томилсон.
- ТУЗ өнгөрөгч онд нийт 13 удаа хуралдаж, 58 тогтоол шийдвэр гаргасны 24 нь АПУ компанийн ТУЗ-ийн бүрэн эрхийн хүрээнд, бусад нь охин болон хараат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийн хүрээнд гарсан байна.
- ТУЗ дэргэдээ Аудит, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хороотой ажилладаг ба хороодын дарга бүгд, гишүүдийн 2/3 нь хараат бус гишүүн юм.
- ТУЗ-ийн гишүүний татвар, суутгал хасаагүй сарын үндсэн цалинг өмнөх оныхоос өөрчлөлтгүйгээр буюу ТУЗ-ийн дарга 10 сая, ТУЗ-ийн гишүүд 6.5 сая, сар бүр мөнгөн хэлбэрээр олгож, нэмэлт урамшуулал, хөлс олгохгүй байх санал оруулж байна.

Асуулт хариулт:

Хувьцаа эзэмшигч Г.Отгонбаяр:

- Хувьцааны ханш хэлбэлзэлтэй байна, сүүлийн жилүүдэд унасан ханшийг урт хугацаанд өсөлттэй байхад ямар арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа вэ? Степпе Бэвэриж компани хувьцаа эзэмшигч хэвээр байх уу?

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг хариулсан нь:

- Степпе Бэвэриж компани хувьцаа эзэмшигч хэвээр байх эсэхийг бид мэдэхгүй. Хөрөнгийн бирж дээр чөлөөтэй арилжаалагдаж байгаа хувьцаа учраас тухайн хөрөнгө оруулагчийн шийдвэр. Бид хувьцааны болон компанийн үнэ цэнийг өндөр байлгахын тулд компанийн засаглал, сонирхлын зөрчилтэй хэлцлүүд, шийдвэр гаргалт, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, тогтвортой хөгжлийн зорилтыг тодорхой байлгаж, хийснээ ил тод, нээлттэй мэдээлэх соёл, хариуцлагыг улам дээшлүүлнэ. Эдгээр нь ХК-ийн үнэ цэнтэй байх том суурь ойлголт юм. Мөн ТУЗ-өөс ногдол ашгийн бодлогод өндөр ач холбогдол өгч, тэргүүн эрэмбэд авч үздэг. Бид ногдол ашгийг жилд 2 удаа, цэвэр ашгийнхаа 70%-80%-аас доошгүйгээр хуваарилж цаашдаа ч нэмэгдүүлэх бодлого барьж байгаа нь хувьцаа эзэмшигчдэд үнэ цэнтэй байх хөшүүрэг хэмээн бодож байна.

Хувьцаа эзэмшигч Б.Амарбаясгалан:

- Компанийн ирээдүйн 5 жилийн төлөвлөгөө, цаашид хэрэгжүүлэхээр ажиллаж буй төслүүдийн мэдээлэл өгнө үү.

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг хариулсан нь:

- Бид 2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн стратегиа 5 тулгуур баганаар тодорхой гаргасан. Үүний нэг нь тогтвортой түнш байх зорилт юм. Бизнесээс ашиг хүртэгч нь зөвхөн хувьцаа эзэмшигч, ажилтнуудаар хязгаарлагдахгүй, ханган нийлүүлэгч, харилцагч, хамтрагч, хэрэглэгч нарт үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилтуудыг тавьж ажиллаж байна. Үүний нэг нь Монт як буюу Архангай аймгийн Чулуут суманд эхэлсэн гэр үйлдвэрлэлийн төсөл бөгөөд бизнесийн оролцогчдыг өргөжүүлэх томоохон санаачилга юм. Мөн байгаль орчинд ээлтэй байх,

нөлөөллөө багасгах, бүтээмжийг дээшлүүлэх, хамтрагч, харилцагчдынхаа орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтууд хийнэ. Түүнчлэн, цахим засаглалыг дэмжих, шийдвэр гаргалтыг түргэсгэх, үйл ажиллагааг сайжруулах чиглэлд гурван жилийн хугацаанд 80 орчим тэрбум төгрөгийг дижитал шилжилт хийхэд төсөвлөсөн. Үйлдвэрийн тоног төхөөрөмж, технологийг шинэчлэхээр зорьж ажиллан, сүүний бизнесийг өргөтгөх чиглэлд 160-170 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийж байна. Эдгээр нь бүгд бизнесийн өсөлтөд чиглэсэн хөрөнгө оруулалтууд юм.

Хувьцаа эзэмшигч Ц.Оюунсайхан:

- Борлуулалтын тоо хэмжээ өсөөгүй байтал, борлуулалтын орлого, цэвэр ашиг ихээхэн өссөний шалтгаан юу вэ?

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг хариулсан нь:

- Бид бүхий л түвшинд өртөг, зардал хэмнэх чиглэлд ихээхэн хүчин чармайлт гаргасан, бүтээгдэхүүний багцыг оновчлон, үнэ цэнтэй, ашигтай бүтээгдэхүүнүүдийг санал болгоход анхаарсны үр дүнд ашигт ажиллагаа нэмэгдсэн.

Өөр асуулт байсангүй.

Тооллогын комиссын дарга С.Дөлгөөн цахим системээр санал өгөх зааврыг танилцуулж, санал хураалт эхэлснийг мэдэгдэв. Санал хураалт 5 минутын турш явагдаж дууссаны дараа санал хураалтын дүнг нэгтгэв.

Тооллогын комиссын дарга С.Дөлгөөн санал хураалтын дүнг танилцуулахдаа:

Хурлаар дараах асуудлуудыг ердийн аргаар санал хураан шийдвэрлэв.

1. АПУ ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах:

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
935,230,348	99.9998%	50	0.00001%	1,730	0.0002%

2. АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллыг батлах:

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
935,222,071	99.9989%	2,952	0.0003%	7,105	0.0008%

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Сарантунгалаг тооллогын комиссын дүнд үндэслэн хурлаас гарах тогтоолын төслийг танилцуулаад, хурлыг хаана уу хэмээн хурлын дарга Ц.Эрдэнэбилэгийг индэрт урив.

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг хурлыг хааж үг хэлэхдээ:

“Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдэдээ чин сэтгэлийн талархлаа илэрхийлье. 2025 он амаргүй жил болох төлөвтэй ч бид нарийвчилсан тооцоо судалгаанд үндэслэн өртөг зардлаа бууруулж, борлуулалтаа өсгөн өнгөрсөн оныхоо ашгийн түвшнийг хадгалан, өсгөхөөр хичээн ажиллах болно. Та бүхнээс үндэсний үйлдвэрлэлээ дэмжин, өөриймсөг сэтгэлээр бидэнтэй хамтран ажиллахыг хүсэхийн ялдамд эрүүл энх, сайн сайхныг хүсье” гэв.

Хурлын шийдвэр:

1. АПУ ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлав.
2. АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллыг батлав.

Хурал 15 цаг ~~17~~ минутад дуусав.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Төлөөлөн удирдах зөвлөлийн
нарийн бичгийн дарга



Б.Сарантунгалаг

ХЯНАСАН:

Хурлын дарга



Ц.Эрдэнэбилэг